

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2011 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 49

Дархан

Тэмдэгтийн хураамжийн хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 35 дугаар зүйлийг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дархан-Уул аймгийн төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.
2. Аймаг, сумын төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийг шинэчлэн тогтоосон албан татварын хэмжээг 2011 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдүүлэн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Л.ГҮНЧИН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2011 оны 49 дүгээр тогтоолын
Хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ХУРААХ ТЭМДЭГТИЙН
ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн нэр	Тэмдэгтийн хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
1	Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход	500.000
2	Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход	100.000
3	Ус хэрэглэгчид газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх зөвшөөрөл олгоход	240.000
4	Ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс бага ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд	80.000
5	Ус ашиглагчтай гэрээг сунгахад	50.000
6	Усны барилга байгууламж гэрээгээр эзэмших, ашиглах эрх олгох, эрх сунгахад	100.000
7	Ан амьтныг эзэмших зөвшөөрөл олгоход	84.000
8	Нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл олгоход	70.000
9	Хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэгт амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэх ба ийм хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг олгоход	14.000
10	Ан амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, хуулийн этгээдэд суман дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгоход	3.000
11	Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын ан амьтан агнах, барих гэрээ байгуулахад	1.000.000
12	Мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэхэд гарал үүслийн гэрчилгээ олгоход	
-	0-10 толгой мал тутамд	3.000
-	10-аас дээш тооны толгой мал тутамд	3.000
-	10-аас дээш тооны талын толгой тутамд	100 төгрөг нэмж
13	Ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд	3.000
14	Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход	1.000

15	Элбэг ургамлыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд түүж бэлтгэхэд нойтон жингийн килограмм тутамд	10.000
16	Ойн дагалт нөөцийг ашиглах эрхийн бичиг олгоход	
-	0-10 килограмм	1.500
-	10 килограммаас дээш	1.500
-	10 килограммаас дээш тооцсон хэмжээний килограмм тутамд	80
17	Мал эмнэлэг үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хоёр буюу түүнээс дээш сумын нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн олгоход	
-	Хуулийн эдгээдэд	200.000
-	иргэнд	160.000
18	Мал эмнэлэг үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сумын нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн сумын Засаг дарга олгоход	80.000
19	Мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход	2.000
20	Рашаан ашиглах, савлах зөвшөөрөл олгоход	320.000
21	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход	
-	Аймгийн төвийн суманд	600.000
-	Бусад суманд	300.000
22	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад	
-	Аймгийн төвийн суманд	100.000
-	Бусад суманд	50.000
23	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход	
-	Аймгийн төвийн суманд	100.000
-	Бусад суманд	50.000
24	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад	
-	Аймгийн төвийн суманд	50.000
-	Бусад суманд	20.000
25	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход	
-	Аймгийн төвийн суманд	800.000
-	Бусад суманд	500.000
26	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад	
-	Аймгийн төвийн суманд	200.000

-	Бусад суманд	100.000
27	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход	
-	Аймгийн төвийн суманд	400.000
-	Бусад суманд	250.000
28	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад	
-	Аймгийн төвийн суманд	80.000
-	Бусад суманд	50.000
29	Сүүн бүтээгдэхүүн нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход	100.000
30	Мод, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ олгоход	
-	6 м ³ хүртэл	2.000
-	6-10 м ³ хүртэл	3.000
-	10-20 м ³ хүртэл	4.000
-	20-60 м ³ хүртэл	10.000
31	Ойгоос хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгоход	
-	8 м ³ хүртэл	1.500
-	8 -10м ³ хүртэл	2.000
-	10-20 м ³ хүртэл	3.500
-	20-30 м ³ хүртэл	5.000
32	Ойгоос түлээ бэлтгэх эрхийн бичиг олгоход	
-	0-10м ³	1.000
-	10-20м ³	1.200
-	20-30 м ³	1.500
33	Арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэсэн модонд гарал үүслийн гэрчилгээ олгоход	
-	0-10 куб.метр	1.500
-	10 куб.метрээс дээш	1.500
-	10-аас дээш сийрэг куб метр тутамд	150 төгрөг нэмж
34	Ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, дүнз, зүсмэл материалыг өөр аймаг, сум, хот суурингийн хооронд тээвэрлэх, худалдах мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгоход	
-	0-10 куб.метр	1.500
-	10 куб.метрээс дээш	1.500
-	10-аас дээш сийрэг куб метр тутамд	150 төгрөг нэмж